

**“МОНГОЛЫН ТУСГААР ТОГТНОЛ БА ХЯТАД, ОРОС,
МОНГОЛ ГУРВАН УЛСЫН ХИАГТЫН ГЭРЭЭ
(1911-1916)”-НИЙ ТУХАЙ БҮТЭЭЛ**

*С.Дамдинсүрэн**

Өгүүлэн буй бүтээл нь дотоод, гадаадын олон эрдэмтэд судалчихсан сэдэв юм шиг санагдаж мэдэх юм. Гэвч энэ талаар эрдэмтдийн өнөөг хүртэл туурвисан бүтээлүүдэд судлаачийн хийсэн анализ дүгнэлтээс үзэхэд уг асуудал ямаршуу өргөн агуулгатай, түүхэн үйл явдлын хичнээн их багтаамжтай болох нь харагдаж байна.

Доктор, дэд профессор О.Батсайхан XX зууны Монгол улсын түүхийн гол суурь асуудал болсон төрийн тусгаар тогтнолд холбогдох нэн чухал сурвалжийг иж бүрнээр нь анх удаа дагнан судалж, нарийвчлан гүнзгийрүүлж шинжилсэн нь манай түүх судлалд үнэтэй хувь нэмэр болж байна. Энэ бүтээл нь уг сэдвийн судлагдсан байдал, судалгааны чиглэл, зорилтыг тодорхойлсон удиртгал, “XX зууны эхэн үеийн Монголын байдал” (1900-1911) хэмээх нэгдүгээр бүлэг, “Монгол улсын тусгаар тогтнолын сэргэлт ба түүний гадаад нөхцөл, байдал” (1911-1914) хэмээх хоёрдугаар бүлэг, “Хятад, Орос, Монгол гурван этгээдийн 1915 оны гэрээ ба Монгол Улсын олон улсын статус” (1914-1916) хэмээх гуравдугаар бүлэг, “Хятад, Орос, Монгол гурван улсын Хиагтын гэрээний дараах үеийн Монголын олон улсын байдал, цаашдын хувь заяа” хэмээх дөрөвдүгээр бүлэг ба төгсгөлийн дүгнэлт хэсгээс бүрдэж байна. Зохиолын бүтэц, бүлэг, зүйлийн хуваарилалт нь түүхэн үйл явдлын он цагийн дэс дараалал, үүсэл, хөгжил өрнөлтийн явц, логик уялдаа холбоо, харилцан хамаарал, цаг хугацаа, нөхцөл байдал, гадаад дотоод хүчин зүйлийн нөлөөлөл зэрэг бүхий л талыг тусган илэрхийлсэн бөгөөд шинжлэх ухааны арга зүйн өндөр түвшинд боловсрогдсон байна.

Хятад, Орос, Монгол гурван улсын гэрээг байгуулахад хүргэсэн бодит шалтгааныг XIX, XX зууны зааг дээр Ази дахинд бүрэлдсэн улс хоорондын харилцааны шинж төлөв, Монгол орны гадаад, дотоод нөхцөл байдал, Манж гүрний ноёрхлын эсрэг Монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө явуулсан тэмцлийн амжилт, Монгол, Орос, Хятад гурван улсын харилцааны шинэ хүчин зүйлс, харилцан сонирхлын хүрээнд тал бүрээр авч үзэж олон улсын

*С.Дамдинсүрэн – ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D)

эрх зүйн болон бодит харилцааны үүднээс тайлбарласан байна. Энэ нь ч судалсан асуудлаа бүтээлчээр боловсруулах, бодитойгоор үнэлэх бололцоо олгожээ гэж үзнэ.

Доктор О.Батсайханы бүтээл манай түүх бичлэгт харгалзан үзүүштэй шинэлэг санаа, дүгнэлтээрээ ч, улс орныхоо тусгаар тогтнолын төлөө тууштай тэмцсэн төрийн бодлогын баялаг уламжлалыг нээн харуулснаар ч их ач холбогдолтой юм. Түүний судалгааны ажлын шинжлэх ухааны ач холбогдол, үнэ цэнийг тодорхойлж буй шинэ санаа, дүгнэлтүүдийн зарим гол зүйлийг энд онцлон тэмдэглэх хэрэгтэй байна.

Монголын төрийн тусгаар тогтнолын ололтыг хамгаалан баталгаажуулахын төлөө, есөн сар шахам үргэлжилсэн Гурван улсын хэлэлцээрийн турш Монголын төр, засаг, түүний бүрэн эрхт төлөөлөгчдөөс явуулсан шантаршгүй, шаргуу тэмцлийн үнэ цэнийг бодитой дүгнэн харуулж, гурван улсын гэрээгээр Монголын тусгаар тогтнолыг цуцалсан гэж үзсээр ирсэн хуучин дүгнэлтийг няцааж, Монгол нь эзэн хаантай, үндэсний засгийн газартай, өөрийн цэрэгтэй, хилийн тодорхой шугамтай, өөрийн дотоод асуудлыг бие дааж шийдэх бүрэн эрхтэй, гурван улсын хэлэлцээрт Хятад, Орос хоёртой эн зэрэгцэн олон улсын харилцааны субъектын хэмжээнд оролцсон зэрэг тодорхой хэлбэрээр өөрийгөө хадгалан үлдэж чадсаныг бүрнээ баримтжуулан нотолжээ.

“Хиагтын гурван улсын гэрээгээр Орос, Хятад, Монгол гурван этгээдийн сонирхолд ямар нэгэн хэмжээгээр нийцсэн байдлаар Монголын оршин тогтох хэлбэр хийгээд дотоод, гадаад эрхийн хэм хэмжээг тогтоосноор Монгол улсын олон улсын статус тодорхойлогджээ” гэсэн дүгнэлт, “Монгол улс 1911 онд тунхаглан зарласан тусгаар тогтнолоо Хиагтын гэрээгээр хязгаарлуулсан ч хоёр хөршөөрөө эвдүүлэхгүй байх эрх зүйн баталгааг бий болгосон” гэсэн дүгнэлт нь ч гурван улсын гэрээ нь Монголын тусгаар тогтнолыг цуцлаагүй гэсэнтэй логик уялдаатай байна. Гурван улсын гэрээ бол 1911 онд сэргээн тунхагласан төрөө зарим талаар бэхжүүлэх алхам болсон бөгөөд цаашдаа олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх эхлэл тавьсан гэдэг дүгнэлт бас хийжээ.

Монголын тусгаар тогтнолын хэрэгт гадаад хүчин зүйлийн үүргийг хэтрүүлэн үнэлж дотоод хүчин зүйлийн үүрэг, ач холбогдлыг бууруулж байсан өрөөсгөл хандлагыг даван туулах чиглэлээр судлаач олон шинэ санаа дэвшүүлсний дотор Монгол хөрш хоёр орноос ямагт хамааралтай байсан юм уу, хөрш хоёр гүрэн ч гэсэн Монголоос олон

талаар хамааралтай байсан бус уу гэдэг сонирхолтой асуудал дэвшүүлжээ.

Хэлэлцээрт оролцсон Монгол, Орос, Хятадын төлөөлөгчдийн намтрын мэдээллийг судлан тодруулж тавьсан нь түүхэн үйл явдлыг эзэнгүйдүүлдэг урьдын дутагдлыг даван туулах, Монголын төлөөлөгчдийн гүйцэтгэсэн үүргийг үнэн зөв үнэлж түүхэн байр суурийг нь зохих түвшинд тавих, эх оронч шилдэг уламжлалыг сэргээх чухал зүйл юм. Монголын төр, засгийн эрх баригчид, түүний бүрэн эрхт төлөөлөгчид улс орныхоо тусгаар тогтнол, биеэ даасан байдлыг баталгаажуулахын төлөө тэмцэхдээ Монгол улс бол угаас Хятадаас тусдаа оршин тогтсоор ирсэн түүхэн уламжлалаа үндэс болгохын зэрэгцээ 1911 онд Хятадаас түрүүлж Манжийн ноёрхлоос салж тусгаар тогтнолоо тунхаглан зарласан бодит үнэнийг шаргуу тууштай хамгаалсныг хийгээд хуралдаанаас гадуур Монголын төр засгийн явуулсан үйл ажиллагааны цар хүрээ, далайцыг судлаач хуралдааны өдөр тутмын протокол болон хуралдаанаас гадуур харилцаж байсан бичиг баримт, төр засгийн шийдвэр зэрэг баялаг сурвалжид тулгуурлан бүх талаар нээн харуулснаараа түүхэн үнэнийг сэргээхэд үнэтэй хувь нэмэр оруулжээ.

Зохиолд Монголын тусгаар тогтнолын төлөө тэмцлийн амин чухал асуудлыг Монголын үндэсний нэгдлийн асуудалтай холбож, монгол овогтны нийтлэг сонирхол, нэгдмэл эрх ашигтай нягт уялдаатай тавьж байсан түүхэн уламжлалыг нээн харуулахын хамт Хиагтын гэрээ нь монголчуудын хуваагдмал байдлыг баталгаажуулсан туйлын сөрөг үр дагавар, хойчийн үед дамжин лавшрах уршиг тарьсаныг шүүн харуулж, монгол овогтны хуваагдмал байдлыг даван туулах, үндэсний нэгдлийг хангах асуудал бол Монголын ард түмний үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцлийн салшгүй хэсэг болж үлдсэнийг нотолсон байна.

Доктор О.Батсайхан шинжилгээ судалгааныхаа шинэ санаа, дүгнэлт бүрийг түүхэн баримтаар баталгаажуулж, XX зууны Монголын түүх, түүнчлэн дэлхийн Монгол судлалд урьд өмнө судалгааны эргэлтэнд ороогүй байсан 1915 оны Хятад, Орос, Монгол гурван этгээдийн Хиагтын хэлэлцээрийн өдөр тутмын хуралдааны протокол, дэлгэрэнгүй тэмдэглэлийг нийтийн хүртээл болгож, Орос, Монголын архивуудад олон арван жилээр нууцын зэрэглэлтэй хадгалагдаж байсан баялаг баримт, сурвалжийг эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулсан байна. Гэрээний франц, орос, монгол хэл дээр үйлдсэн жинхэнэ эхийг

энэхүү номын хавсралтанд анх удаа нийтэлсэн нь уг бүтээлийн үнэ цэнийг улам өргөж байна.

Цаашдын судалгаанд анхаарууштай зарим зүйлийг энд дурьдах нь зүйтэй болов уу гэж үзэж байна. Үүнд: Энэхүү бүтээлд Монгол, Оросын сурвалж материал, эрдэм шинжилгээний суурь бүтээлд нэлээд өргөн анализ хийж, Хятадын зарим сурвалжийг тусгасан боловч Хятад, Японы энэ талаарх судалгааны бүтээл, сурвалжийн судалгааг аль болох өргөтгөх; Гурван улсын хэлэлцээрт Монголын байр суурийг тодорхойлох, хамгаалах, баталгаажуулах талаар Богд Жавзандамба хаан, Ерөнхий сайд Намнансүрэн зэрэг төр засгийн дээд удирдлагын байр суурь, үйл ажиллагааг энд тэнд дурьдаж байгаа боловч бүхэл цогцолбороор авч үзэж нэгтгэн дүгнэх; 1911 онд Монголын тусгаар тогтнолыг зарлан тунхагласан үйл явдлын түүхэн үнэлгээг онол, арга зүйн үүднээс улам чамбайруулмаар санагдана.

Энэхүү нэгэн сэдэвт зохиолыг бүхэлд нь эрэгцүүлбээс асуудлын мөн чанар, гүн агуулга, өргөн багтаамжийг нээн харуулсан тал бүрийн анализ, ургуулан гаргасан үнэлэлт, дүгнэлтүүд нь шинэлэг санаа, эрдэм шинжилгээний өндөр түвшинд боловсрогдсон, сурвалж судалгааны гүнд нэвтэрч задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргыг чадварлаг хэрэглэсний үр дүнд эрдэмтэд түүхчид судлаачдын сонирхлыг зүй ёсоор татаж байна. Ялангуяа Монгол нь Хиагтын хэлэлцээрээр тусгаар тогтнолоо цуцлаагүй хамгаалж чадсан, цаашдаа ч түүнийг эвдүүлэхгүй байх эрх зүйн баталгааг хоёр хөршөөрөө гаргуулж чадсан гэсэн дүгнэлт нь манай түүх судлалд тсгтсон олон хуучин ойлголтыг хянан үзэх, шинээр хандах хэрэгтэй болохыг харуулснаараа шинжлэх ухааны өндөр түвшинд тавигдах ач холбогдолтой бүтээл болжээ гэдгийг дахин дурьдмаар байна.